



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 0/2017

Улаанбаатар хот

Программ хангамжийг үйлдвэрлэлийн  
үйл ажиллагаанд турших тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, ИНД-172.157 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын техник, технологийн зөвлөлийн 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэр, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2018 оны А/30 дугаар тушаалаар байгуулагдсан туршилт хийх ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийг тус тус харгалзан иргэний нисэхийн ерөнхий газарт хэрэгжүүлж буй Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн программ хангамж хөгжүүлэх төсөл /ATFMS/-ийн нэгдүгээр үе шатны программ хангамжийг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд турших ажлыг тушаал гарсан өдрөөс эхлэн 6 сарын хугацаатай хийж гүйцэтгэсүгэй.

2. Турших ажлыг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нөлөөлөхгүйгээр зохион байгуулж, тайлан, дүгнэлтийг туршилтын ажил дууссан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор удирдлагад танилцуулахыг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба /П.Мөнхжаргал/-нд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтэс /Ё.Эрдэнэбат/-т даалгасугай.



Л.БЯМБАСҮРЭН